

**"АПУ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 26/01.....

Улаанбаатар хот

АПУ ХК (цаашид "Компани" гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 14 цаг 00 минутад эхлэв. Хурлыг БиДиСек ҮЦК ХК-ийн хөгжүүлсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын www.agm.mn програм хангамжийн тусламжтай, Лайвстрийм ХХК-ийн шууд дамжуулалтаар явуулав.

Хуралд оролцсон:

1. Гүйцэтгэх захирал бөгөөд хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
2. Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ" гэх)-ийн хараат бус гишүүн, Цалин урамшууллын хорооны дарга Ё.Гэрэлчулуун
3. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга О.Одбаяр
4. ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга Ж.Үнэнбат (цахим)
5. Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг
6. Хөндлөнгийн аудитор PwC Аудит ХХК-ийн аудитын партнер Шаукат Тапия (цахим)
7. Хөндлөнгийн аудитор PwC Аудит ХХК-ийн аудитын захирал Ц.Баттуяа
8. Хөндлөнгийн аудитор PwC Аудит ХХК-ийн аудитын менежер Б.Билгүүн
9. Тооллогын комиссын дарга Бидисек ҮЦК ХК-ийн Б.Онон

Хурлын нарийн бичгийн дарга:

1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хурлын дэгийн дагуу бүртгэлийн ажиллагааны дүнг гаргаж, ирцийн мэдээг танилцуулна уу хэмээн тооллогын комиссын дарга Б.Ононг урив.

Хэлэлцэх асуудал:

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох,
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох,
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Б.Ононгийн танилцуулснаар:

Хуралд **935,993,727 ширхэг** энгийн хувьцаа эзэмшиж буй **126** хувьцаа эзэмшигч оролцож байгаа нь нийт саналын эрхтэй **1,064,181,553 ширхэг** энгийн хувьцааны **87.95%** болж байгаа тул Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь хэсэг, Компанийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсгийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөрт тооцов.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг ирц бүрдсэн тул хурлын дарга Ц.Эрдэнэбилэгийг хурлыг нээж, нэгдүгээр хэлэлцэх асуудлыг танилцуулахыг урив.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулахдаа дараах зүйлсийг онцлов (танилцуулгыг хавсаргав). Үүнд:

- Өнгөрөгч 2025 онд АПУ компанийн хувьд, шингэн хүнс тэр тусмаа шар айргийн хувьд асар их өрсөлдөөнтэй жил байлаа. Зөвхөн 2025 онд импортоор 200 гаруй нэр төрлийн шар айраг Монголын зах зээлд нэвтэрч, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих бодлого хэрэгжүүлсэн боловч импортын бүтээгдэхүүнүүд зах зээлд олноор нэвтэрсэн жил байлаа. Гэсэн хэдий ч та бүгдийн дэмжлэгээр, компанийн нийт 2,500 гаруй ажилчдын өөриймсөг, өртөг зардлаа хэмнэсэн, шинэ бүтээгдэхүүн, шинэ технологийг бий болгосон амжилттай он жил байлаа.
- Нийт үйлдвэрлэлд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэлээдгүй жин нэмсэн, ус ундаа, жүүсний үйлдвэрлэлд анхаарал хандуулсан, шар айраг исгэлтийн үйлдвэрүүдэд шинэ тоног төхөөрөмж технологийг нэвтрүүлсэн, спирт, архины үйлдвэрлэлд цоо шинэ бүтээгдэхүүнийг бий болгосон жил болов.
- Борлуулалтын тоо хэмжээ биет хэмжээгээр, өнгөрсөн оны аудитлагдсан тайлангаас 7% орчмоор буурсан нь голчлон шар айраг, ус ундааны үйлдвэрлэлийн бууралттай холбоотой. Харин архи, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өнгөрсөн жилээс өссөн үзүүлэлттэй гарсан. Цэвэр борлуулалтын орлого өнгөрсөн жилтэй харьцуулахад бага зэргийн бууралттай байна.
- Үйл ажиллагааны ашиг 11.7% орчим буурсан нь зардлын өсөлт буюу 1-рт ажилчдын цалинтай адилтгах орлогуудад анхаарсан, нөгөөтээгүүр өрсөлдөөнд ялалт байгуулахын тулд маркетингийн болон бүтээгдэхүүн үйлчилгээний зардал, эцсийн хэрэглэгч дээрх зардлыг өсгөсөнтэй холбоотой.
- Тайлант үеийг өнгөрсөн онтой харьцуулбал бага зэргийн бууралттай боловч нийт 207.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Балансын хувьд эздийн өмч 15% орчим өссөн. Мөнгөн гүйлгээ жилийн эцсээр 108 тэрбум төгрөг буюу өнгөрсөн жилээсээ 38.7%-ийн өсөлтийг бас үзүүлжээ.
- Монгол Улсын төсөвт нийт 514 тэрбум төгрөгийн татвар төлж, өнгөрсөн жилээсээ 8.4%-ийн өсөлтийг бий болгожээ. Бид 2024 оноосоо 1.1% цөөн ажилчидтайгаар, бүтээмжээ өсгөхөд нэлээд хичээж ажиллалаа. Бүтээгдэхүүний нэр төрөл маань 4.6% буюу 2025 онд бид 636 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дэлхийн хэрэглэгчдэдээ хүргэж ажиллалаа.
- 2025 онд бид ₮138 тэрбумын ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараасан нь өнгөрсөн онтойгоо харьцуулбал 8.1% өсөлт юм.

ТУЗ-ийн хараат бус гишүүн, цалин урамшууллын хорооны дарга Ё.Гэрэлчулуун АПУ компанийн ТУЗ бүрэн эрхийнхээ хүрээнд 2025 онд нийт 10 удаа, 100%-ийн ирцтэй хуралдаж, 45 тогтоол шийдвэр гаргаж ажилласнаа тайлагнав. Улмаар 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн “АПУ групп компани 2025 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг танилцууллаа.

Асуулт хариулт:

Хувьцаа эзэмшигч Энхтөр:

- Ноос угаах үйлдвэрийн суурин дээр баригдаж байгаа барилгад АПУ компани хөрөнгө оруулсан уу, оруулсан бол цаашид ямар чиглэлээр ашиглах вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

Ноос угаах үйлдвэрийн суурин дээр баригдаж байгаа барилгад Шунхлай групп хөрөнгө оруулсан, АПУ ХК хөрөнгө оруулаагүй. Харин хажууд нь байгаа АПУ Дэйри компанитай залгаа тодорхой газарт хөрөнгө оруулж, 140-150 тэрбум төгрөгийн өртөг бүхий сүүний үйлдвэрлэлийн өргөтгөлийг ашиглалтад оруулахад бэлэн болж байна. Тус хөрөнгө оруулалтын үр дүнд АПУ Дэйри компанийн хүчин чадлыг үндсэндээ 2 дахин өсгөж, шинэ бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчдэдээ хүргэх томоохон ач холбогдолтой төсөл хэрэгжиж дуусаж байгаа.

- Борлуулалтын хэдэн хувийг экспортын борлуулалт эзэлж бна вэ, цаашдын төлөв, төлөвлөгөө ямар бна?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

Экспортын хувьд маш хэцүү сорилтуудыг даван туулж байна. Ялангуяа энэ хямралын үед том гүрнүүд дотоодынхоо үйлдвэрлэлийг дэмжих, импортыг хязгаарлах бодлогуудыг маш хүчтэй явуулж байна. Манай 100%-ийн эзэмшлийн хоёр охин компани ОХУ-д, нэг охин компани БНХАУ-ын Өвөр Монголын Хөх хотод үйл ажиллагаа явуулж байна. Хэдийгээр бид өнгөрсөн онд 20% орчим өсөлт гаргаж чадсан боловч хөрөнгө оруулалтын өгөөж, нийт борлуулалтад эзлэх хувь хэмжээ чамлахуйц байгаа. Гэвч бид зогсолтгүй, тууштай ажиллаж илүү шинэлэг байж, экспортын зах зээлд нэвтрэх чин сэтгэл байна.

- Өмнөх онуудын тайлангийн үеэр сарлагийн хөөвөр бэлтгэх, үйл ажиллагаа явуулах талаар яригдаж байсан энэ ажил ямар шатанд явж байна вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

Сарлагийн хөөвөртэй холбоотой энэ асуултыг Говь компани эсвэл энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг өөр компанитай андуурч асуусан байх магадлалтай. Бид сарлагийн сүүн бүтээгдэхүүн буюу гэр үйлдвэрлэлийг дэмжих “Mont Yak” төслийг Архангай аймгийн Чулуут суманд хэрэгжүүлээд гурван жил болж байна. Энэ төслөөр малчид хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг манай компанид нийлүүлж, бид эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн “Mont yak” гэх гайхамшигтай брэнд, жинхэнэ органик брэндийг гаргаж ирсэн нь цаашид үргэлжлэх болно.

Хувьцаа эзэмшигч Чулуун:

- Эдийн засгийн хямралыг хэрхэн даван туулах вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

Гүйцэтгэх захирал, түүний удирдлагын баг эдийн засгийн хямралын эрсдэлийг удирдах цогц төлөвлөгөө гаргаж ногоон, шар, улбар шар, улаан гэсэн 4 өнгөөр үйл ажиллагааны зардал, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлд гаргаж буй бүтээгдэхүүний төлөвлөлт гаргасан. Хамгийн чухал нь бид өртөг зардлаа хэмнэх, оновчлох тал дээр юу хийх, юу хийхгүйг энэ төлөвлөгөөгөөрөө нарийн гаргаж, батлаад, хэрэгжүүлж байна.

Хувьцаа эзэмшигч Энхтөр:

- 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний талаар?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

ТУЗ-ийн шийдвэрээр 2026 онд 190 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр баталсан болно. Үүний 80 тэрбум төгрөгийг Tiger үйлдвэр дээр Баянзүрх дүүрэг болон зүүн аймгуудыг хангахуйц логистик төв, автомат агуулахын төсөлд зарцуулна. Мөн саарал ус дахин боловсруулах төсөлд, тэжээлийн үйлдвэрийн эхлэлийг тавьж, эхний үе шатыг ашиглалтад оруулахад нэлээд том зардал төсөвлөсөн. Гуравдугаарт бизнесийн үйл ажиллагаанд буюу бүтээгдэхүүний чанар, өнгө үзэмжийг дээшлүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн. Түүнчлэн, хүний хөгжилд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж байна. Эдгээр нь 2026 онд нэлээд том ахиц дэвшлийг дагуулна гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Мөнхдэмбэрэл:

- Компани GS25-ын хувь эзэмшиж байгаа. Эхний дэлгүүрээс өнөөдрийг хүртэл нийт хэдий хэмжээний хөрөнгө оруулалт GS25-д хийсэн бэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

Энэ хөрөнгө оруулалт бол богино хугацааны гэхээс илүүтэй урт хугацаанд ашиг авчрах том төсөл юм. Бид дийлэнх хувьцааг эзэмшдэггүй учраас GS25-ын үйл ажиллагааг шууд тайлагнах боломжгүй.

Хувьцаа эзэмшигч Энхтөр:

- Өнгөрсөн онтой харьцуулахад компанийн ажиллагсдын тоо хэр өөрчлөгдсөн бэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

Бид бүтээмжээ сайжруулахад онцгой анхаарч 2024 онтой харьцуулахад ажиллагсдын тоо 1% орчим цөөлсөн. Дижитал засаглалыг сайжруулах, автоматжуулалтад хөрөнгө оруулалтууд хийж байна. Цаашдаа ч бүтээмж, чанарт түлхүү анхаарч ажиллана.

- Ажиллагсдын дундаж цалин хэд вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хариулсан нь:

Ажиллагсдын дундаж цалингаас илүү тухайн мэргэжлийн хүмүүсийн өрсөлдөх чадвар, ижил мэргэжлийн хүмүүсийн цалинтай адилтгах үзүүлэлт чухал гэж бодож байна. Бид салбарын хувьд болон инженер, менежер, санхүүгийн ажилтны хувьд гээд бүх тал дээр Монгол Улсад ажиллаж байгаа ААН-үүдээс дунджаар 10%-20%-ийн өндөр цалингийн тогтолцоог бий болгосон.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох,
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн хараат бус гишүүн, нэр дэвшүүлэх хорооны дарга О.Одбаяр ТУЗ-ийн ердийн гишүүн Сэн И-Ингийн оронд шинээр Шелли Колиг нэр дэвшүүлэхээр хувьцаа эзэмшигч Хайнекен Азиа Пасифик Пте.Лтд компаниас санал гаргасан тул Нэр дэвшүүлэх хорооноос ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэлдэхүүнийг сонгохоор шийдвэрлэснийг дурдав. Улмаар ТУЗ-д нэр дэвшсэн 9 хүнийг, үүнд шинээр нэр дэвшигч хуульч, эдийн засагч, улс төр судлаач мэргэжилтэй Шелли Колиг дэлгэрэнгүй танилцуулав.

Асуулт хариулт: Асуулт байсангүй.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах

ТУЗ-ийн хараат бус гишүүн, цалин урамшууллын хорооны дарга Ё.Гэрэлчулуун “АПУ ХК-ийн дүрмийн 7.22.8 дугаар зүйлийг үндэслэн 2022 онд ТУЗ-ийн гишүүдийн үндсэн цалинг ТУЗ-ийн дарга 10 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая төгрөг байхаар тогтоож, баталсан. Үүнээс хойш 2023, 2024, 2025 оны хувьцаа эзэмшигчдийн хурлуудаар энэ хэмжээг өөрчлөлтгүйгээр баталж, мөрдөж ирсэн. Энэ удаагийн хуралд ч мөн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг дээр дурдсан тогтмол хэмжээг сар бүр мөнгөн хэлбэрээр олгох, гүйцэтгэлийн урамшуулал, аливаа нэмэгдэл хөлс олгохгүй байхаар шийдвэрлэх саналыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна” гэв.

Асуулт хариулт: Асуулт байсангүй.

Хэлэлцэх асуудал 2, 3, 4-тэй холбоотой асуулт ирээгүй тул санал хураах ажиллагааг эхлүүлэн, цахимаар санал өгөх зааврыг Тооллогын комиссын дарга Б.Онон танилцуулав.

Санал хураалт явагдаж байх үед “Эс Жи Инвестмент энд Секьюритис ҮЦК” ХХК-аас хөрөнгийн зах зээлийн талаар болон ногдол ашгаар дахин хөрөнгө оруулах DRIP үйлчилгээний тухай товч танилцуулга хийв. Дэлгэрэнгүй мэдээллийг тус ҮЦК-ийн www.sgis.mn цахим хуудсаар зочилж авах боломжтой.

Санал хураалт явагдаж дуусаж, Тооллогын комиссын дарга Б.Онон санал хураалтын дүнг танилцуулав. Үүнд:

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	хувь
935,165,269	99.9999%	1,000	0.0001%	0	0.00%

2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
935,154,799	99.9988%	10,404	0.0011%	1,066	0.0001%

3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
935,132,763	99.9964%	21,666	0.0023%	11,840	0.0013%

Хурлаар дараах асуудлуудыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Пүрэвийн Батсайхан	12.51%	1,053,166,494

2	Бүрэнтогтохын Батбаяр	10.41%	876,278,008
3	Кеннет Чу	12.51%	1,052,838,055
4	Шелли Коли	12.51%	1,052,780,676
5	Батсайханы Гантиг	10.41%	876,277,414
6	Баярцогтын Гомбо-Эрдэнэ	10.41%	876,323,111

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ёндон-Ойдовын Гэрэлчулуун	10.41%	876,261,810
2	Одончимэгийн Одбаяр	10.41%	876,261,935
3	Жигжидийн Үнэнбат	10.41%	876,308,918

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг тооллогын комиссын дүнд үндэслэн хурлын тогтоолыг танилцуулаад, хурлыг хааж үг хэлэхдээ:

“Нийт хувьцаа эзэмшигчдэдээ чин сэтгэлээсийн талархал илэрхийлье. 2026 он бол зөвхөн Монгол Улсын хувьд төдийгүй дэлхий нийтээрээ улс төр, эдийн засгийн олон сорилтуудыг давж туулах хариуцлагатай он жил болж байна. Тэр тусмаа Монголын үндэсний үйлдвэрлэгчдэд илүү хөгжих, ололт амжилтаа бататгах, борлуулалт, ашгаа дээшлүүлэх том хариуцлага тулгарч байна. АПУ ХК-ийн 35 мянга гаруй хувьцаа эзэмшигч эзэд та бүхнээс нэг хүн таван хүнд нөлөөлж, нийт 150 мянган хэрэглэгчийг АПУ компанийнхаа үйлдвэрлэж байгаа 600 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэх үндэсний үзэл, үндэсний үйлдвэрлэлээ дэмжихэд чин сэтгэлээсээ хамтарч ажиллахыг хүсэж, уриалж байна. Та бүгдийн дэмжлэг, итгэл бидэнд маш их хэрэгтэй байна. Хувьцаа эзэмшигчдэдээ талархлаа илэрхийлж, энэ удаагийн ээлжит хурлыг өндөрлөө.” гэв.

Хурлын шийдвэр:

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.
3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаагаар сонгов.
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг сар бүр ТУЗ-ийн дарга 10 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая төгрөг байхаар батлав.

Хурал 15 цаг 15 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

нарийн бичгийн дарга

ХЯНАСАН:

Хурлын дарга



Б.Сарантунгалаг

Ц.Эрдэнэбилэг

АПУ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ 2026

ALWAYS FORWARD

ХУРЛЫН ДЭГ

№	Үйл ажиллагаа	Шийдвэрийн төрөл	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хурлын зохион байгуулалтыг танилцуулах		14:00-14:02	ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг
2	Бүртгэлийн ажиллагааны дүнг гарган, танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	14:02-14:05	Тооллогын комисс
3	Хурлыг нээж, АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах		14:05-14:20	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг
4	2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТҮЗ-ийн гаргасан дүгнэлт, ТҮЗ-ийн ажлын тайланг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:20-14:30	ТҮЗ-ийн хараат бус гишүүн
5	Асуулт, хариулт		14:30-14:35	
6	ТҮЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгаар болгох асуудлыг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:35-14:38	ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг
7	ТҮЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:38-14:45	ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Сарантунгалаг
8	Асуулт, хариулт		14:45-14:50	
9	ТҮЗ-ийн цалин урамшууллын талаарх мэдээллийг танилцуулах	Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол	14:50-14:53	ТҮЗ-ийн хараат бус гишүүн
10	Асуулт, хариулт		14:53-14:58	
11	Цахимар санал өгөх заарыг танилцуулах		14:58-15:00	Тооллогын комисс
12	Хэлэлцэх асуудлуудаар санал хураалт явуулах		15:00-15:05	Тооллогын комисс
13	Санал хураалтын дүн гаргаж, хуралд оролцогчдод танилцуулах	Тооллогын комиссын тогтоол	15:05-15:10	Тооллогын комисс
14	Хурлыг хаах		15:10-15:15	Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
2. АПУ ХК-ийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох,
3. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох,
4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг хэлэлцэж батлах.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ #1

1. АПУ ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

АПУ ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Оноосон нэр: АПУ
Хэлбэр: Нээлттэй хувьцаат компани
Регистрийн дугаар: 2702673
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага: Монголын хөрөнгийн бирж
Хувьцааны бүртгэлийн ангилал: I
Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: 1,064,181,553

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:



ҮРГЭЛЖ ӨӨДӨӨ

ALWAYS FORWARD

ЭРХЭМ ЗОРИЛГО
Шинэ санаачилга, бүтээх тэнүүлээр урлаж буй бүхэндээ үргэлж сэтгэлээ шингээнэ.

АЛСЫН ХАРАА
Дэлхийд танигдах эрхэм Монгол хүмүүний оюун чадвар, ур ухаан, шинэчлэл, тогтвортой хөгжлийн үндэс байх.

ҮНЭТ ЗҮЙЛС
ТАНИХ ЭРМЭЛЭЛ

ЭРЭЛ, ХАЙГУУЛЧ СЭТГЭЭ
Тасралтгүй шинэчлэл, эрэлхийлэл, суралцаж, хуваалдах, туршил.

ҮНЭН ЧАНАР
ХАМТДАА ЯЛЬЯ
Чанарыг эрхэнлэх, ялалтын сэтгэлгээгээр уралшлах.

БҮТЭЭЛЧ ЧАДВАР
ИННОВАЦИЛАГ АЖИЛЛАЯ
Улаасжиг хандгах, шинэчлэл.

ХҮНЛЭГ СЭТГЭЛ
ХҮНДЛЭН ЭРХЭМЛЭЭ
"Хүн" байдлыг чухалчилж, сайн сайхныг түгээх.


2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Тоон үзүүлэлтүүд	Хэмжээ нэгж	Аудитлагдсан НСТ 2025	Аудитлагдсан НСТ 2024	Өсөлт, Бууралт %
БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ	мян.литр	157,630	171,114	-7.9%
ОРЛОГО ҮР ДҮН				
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	1,320,664	1,340,375	-1.5%
Үйл ажиллагааны ашиг	сая.төг	275,541	312,216	-11.7%
Тайлант үеийн цэвэр ашиг	сая.төг	207,857	219,747	-5.4%
БАЛАНС				
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	414,667	391,963	5.8%
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	717,682	990,086	21.6%
Нийт хөрөнгө	сая.төг	1,132,350	982,070	15.3%
Нийт өр төлбөр	сая.төг	290,058	210,039	38.1%
Нийт эздийн өмч	сая.төг	842,292	772,030	9.1%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	сая.төг	1,132,350	982,070	15.3%


Тоон үзүүлэлтүүд	Хэмжээ нэгж	Аудитлагдсан НСТ 2025	Аудитлагдсан НСТ 2024	Өсөлт, Бууралт %
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	272,299	288,244	-5.5%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(196,019)	(116,964)	87.6%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	(46,147)	(180,086)	-74.4%
Бусад мөнгөн гүйлгээ	сая.төг	300	(572)	-152.4%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	сая.төг	30,433	(9,378)	-424.5%
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	сая.төг	78,539	87,917	-10.7%
Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	сая.төг	108,972	78,539	38.7%
ТАТВАР ТӨЛӨЛТ				
Онцгой албан татвар	сая.төг	249,744	244,810	2.0%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	сая.төг	131,731	105,126	25.3%
Бусад	сая.төг	132,908	124,104	7.1%
Нийт татвар төлөлт	сая.төг	514,383	474,040	8.5%

2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

ЦЭВЭР БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО
/тарбум төгрөг/




ЦЭВЭР АШИГ
/тарбум төгрөг/




БОРЛУУЛАЛТЫН ТОО ХЭМЖЭЭ
/сая.литр/




АЖИЛЧДЫН ТОО




БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ
/сая.л/



НОГДОЛ АШИГ
/тарбум төгрөг/



ТАТВАР ТӨЛӨЛТ
/тарбум төгрөг/



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮРЭЛДЭХҮҮНД БУЙ 4 КОМПАНИ МОНГОЛ УЛСЫН "ТОП 100 АЖ АХУЙН НЭГЖ"-ЭЭР ШАЛГАРЛАА

Улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болж, татварын орлогыг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй ТОП-100 аж ахуй нэгжийг Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр алдаршуулдаг хүндэтгэлийн үйл ажиллагаа 24 дэх жилдээ зохион байгуулагдлаа.

Тус жагсаалтад АПУ ХК 22 дахь жилдээ шалгарсан бол АПУ Трейдинг ХХК, Спирт Бал Бурам ХХК, АПУ Дэйри ХХК тус тус шалгарлаа.



"АПУ ДЭЙРИ МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР" СҮҮ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ МАЛЧИД, ФЕРМЕРҮҮДИЙН БОДИТ ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, МЕНЕЖМЕНТИЙГ ОНОВЧЛОХ ШИНЭ ТҮНШЛЭЛ ЭХЛҮҮЛЛЭЭ

Монгол хүний эрүүл мэндийг тэтгэх сүүний хэрэглээг 3 дахин нэмэгдүүлэх зорилгын хүрээнд АПУ Дэйри Монгол сүүний үйлдвэр нь Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам, Хаан банк, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо, Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөлтэй хамтран сүүний фермерүүд болон малчид, тариалан эрхлэгчдэд хамтын өгөөжтэй бодлого, хөрөнгө оруулалт, чанар, стандартыг мэргэжлийн түвшинд хүргэх цогц хамтын ажиллагааг эхлүүлээ.



АПУ ХК БОЛОН АПУ ДЭЙРИ КОМПАНИ 2025 ОНЫ МОНГОЛ УЛСЫНШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР ТОДОРЛОО

2024 онд АПУ компани нь улс, орон нутгийн төсөвт нийт 474 тэрбум буюу өдөрт 1.3 тэрбум төгрөгийн татварын орлого оруулснаар "ТАТВАР ТӨЛӨЛТӨӨРӨӨ ТЭРГҮҮЛЭГЧ - 10" аж ахуйн нэгжээр шалгарлаа.

Мөн 2025 онд АПУ компани нь 514 тэрбум төгрөгийн татвар төлсөн.



"INNOVATION CATALYST"



2013 оноос эхлэн жил бүр Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшилд томоохон хувь нэмэр болсон хамгийн шилдэг бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, бодлого шийдлийг "Bloomberg Awards"-т нэр дэвшүүлэн мөнгөтэй шагналыг тодруулж ирсэн.

Тус арга хэмжээнд АПУ ХК "Шинэ бүтээл, шинэчлэлийн ХҮРДАСГУУР" болж чадсан хэмээн үнэлэгдэж, "INNOVATION CATALYST"-ийн эзэнээр шалгарсан.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

СЭНГҮР БРЭНД ИЛҮҮ ЗӨӨЛӨН, ШИНЭ АМТААР "ШИНЭЧЛЭЛ" ХИЙЛЭЭ

2007 оноос хойш Монголын шар айргийн зах зээлд зөөлөн амтаараа ялгарч, 17 жилийн турш ТОП сонголт болж ирсэн "Сэнгүр брэнд" цоо шинэ амт, өнгө төрхийг урлаж хэрэглэгчдэдээ хүргэлээ. Энэ шинэчлэлээр брэндийн үнэ цэн, өнгө төрх, амт чанар бүхий л түвшинд шинэ шатанд гарч илүү шинэлэг, илүү зөөлөн болж өөрчлөгдлөө.



МОНГОЛЫН АНХНЫ GIN

5 жилийн судалгааны үр дүнд Монголын анхны GIN болох The Founder брэндийг зах зээлд амжилттай танилцуулж борлуулж эхэлсэн нь Монголын шингэн хүнсний зах зээлд шинэ түүхийн хуудсыг нэмсэн үйл явдал боллоо.



ОРГИЛУУН БРЭНД ШИНЭ ДҮР ТӨРХӨӨРӨӨ ХЭРЭГЛЭГЧДЭД ХҮРЛЭЭ

Хийжүүлсэн усны зах зээлд тэргүүлэгч Оргилуун брэнд илүү шинэлэг, өнгөлөг дизайн бүхий шинэ дүр төрхөөр амжилттай шинэчлэгдсэн. Брэндийн энэхүү шинэчлэл нь бүтээгдэхүүний өнгө төрхийг орчин үеийн хэв маягт нийцүүлэн сайжруулж, хэрэглэгчдэд илүү сэргэг, эрч хүчтэй мэдрэмжийг хүргэх зорилготой.



АПУ ДЭЙРИ - МОНГОЛ СҮҮНИЙ ҮЙЛДВЭР НЬ ОЛОН УЛСЫН АМТ, ЧАНАРЫН ӨНДӨР ШАЛГУУРТАЙ "SUPERIOR TASTE AWARD 2025" ШАГНАЛЫН ЭЗЭН БОЛЛОО



Энэхүү шагнал нь International Taste Institute-ээс дэлхийн 200 гаруй шилдэг шүүгч мэргэжилтнүүд үнэлэн олгодог хүнсний салбарын нэр хүндтэй шагнал юм.

Шагнал хүртсэн брэнд бүтээгдэхүүнүүд:

- Pro+ брэнд | Болгар тарваг
- Pro+ | Healthy Milk
- Mont-Yak брэнд | Шар төс

АПУ КОМПАНИЙН БРЭНДҮҮД ДЭЛХИЙД ЧАНАРААР ҮНЭЛЭГДЛЭЭ



Бельгийн нийслэл Брюссельд байрлах Олон улсын чанар, стандартыг тодорхойлогч "Monde Selection" институт нь 1961 оноос эхлэлтэй бөгөөд спирт, архи, шар айраг, хийжүүлсэн ус, цэвэр ус, хүнсний бүтээгдэхүүн, эрүүл мэндийг дэмжих хүнсний нэмэлт бүтээгдэхүүний чанарыг тодорхойлдоггоороо дэлхийд алдартай.

ЭКСПОРТЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Экспортын үйл ажиллагаа нь ОХУ, БНХАУ, БНСУ, Франц, Итали, Швейцарь, АНУ, Татваргүй бараа зэрэг зах зээлүүдэд чиглэн хэрэгжсэн бөгөөд эдгээрээс хэд хэдэн зах зээлд мэдэгдэхүйц өсөлт үзүүлэв.

гүйцэтгэл

119%

өсөлт

19%↑

2025 оны гүйцэтгэлээр АПУ ХХ экспортны зах зээлүүдэд тогтвортой өсөлт үзүүлж, нийт дүнгээр өнгөрсөн онтой харьцуулахад 119%-ийн гүйцэтгэл буюу 19%-ийн өсөлт үзүүлэв.

Тухайлбал:

- Францын зах зээл хамгийн өндөр өсөлттэй байж 151%-ийн өсөлт үзүүллээ.
- Duty Free сегмент тогтвортой тэлж, 21%-ийн өсөлт бүртгэгдсэн.
- ОХУ-ын зах зээл экспортын гол зах зээл хэвээр байж, 29%-ийн өсөлттэй ажиллалаа.
- БНХАУ болон БНСУ-ын зах зээлүүдэд борлуулалтын идэвхжил нэмэгдэж, зах зээлийн суурь тэлэх зэрэг хандлага ажиглагдаж байна.

Стратегийн түвшинд экспортын борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор зах зээл тус бүрдээр тус тус идэвхжүүлэлт болон арга хэмжээг зохион байгуулав.

ГҮЙЦЭТГЭХ ДЭД УДИРДЛАГЫН БАГ



Цэвэрэнжавын **ЗЭРДЭНЗӨБИЛЭГ**
Гүйцэтгэх захирал



Жаргалсайханы **ИЧИНХОРЛОО**
Захираа, Хүний нөөц эрхэлсэн захирал



Балсайханы **ЦАЦРАЛ**
Борлуулалт, маркетинг эрхэлсэн захирал



Гончигийн **ЭНХБИЛЭГ**
Санхүү эрхэлсэн захирал, Төслийн удирдлагын захирал



Галсумьяа **БАЯРМАГНАЙ**
АПУ Дээрх Гүйцэтгэх захирал




АЛЛАН **ОНГ**
Дижитал шилжилт, үерчлэлт эрхэлсэн захирал



Георгий **Губеладзе**
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа эрхэлсэн захирал

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

ГРУПП КОМПАНИЙН БҮТЭЦ





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигч	2024 оны эцэс		2025 оны эцэс	
	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг	Нийт гаргасан хувьцаанд эзлэх хувь
1 Шунхлай Холдинг ХХК	602,651,260	56.63	602,651,260	56.63
2 Heineken Asia Pacific Pte Ltd	266,091,981	25.00	266,091,981	25.00
3 Steppe Beverage KFT	59,351,609	5.58	58,829,058	5.53
4 Бусад	136,086,703	12.79	136,609,254	12.84

Өмнөх онтой харьцуулбал нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Степпе Бэвэриж КФТ-ийн эзэмшлийн хувьцаа 522,551 ширхэг буюу 0.05%-аар буурч олон нийтийн эзэмшилд шилжжээ.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн тоогоор тэргүүлэгч топ-5 хувьцаат компани



ҮЦДТХТ ХХК-аас гаргасан үнэт цаасны тийгэрэлд судалараны мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн тоо




АПУ компани 2025 оны эцэст 34,918 хувьцаа эзэмшигчтэйгээр хувьцаат компаниуд дунд дөрөвдүгээрт эрэмбэлэгдэн байв.

АПУ ХК-ийн хаалтын ханшийн хөдөлгөөн, 2025 он (төгрөгөөр)



Хувьцааны хаалтын ханш:
Оны эхэнд 1000 төг
Оны төгсгөлд 977 төгрөг
Жилийн дээд 1,006 төг
Дундаж 952 төг
Доод ханш 902 төг байв.

НОГДОЛ
АШИГ



АПУ ХК-ийн ТУЗ-өөс 2025 оны нийлбэр дүнгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 130 төгрөг, нийт 138 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваариллаа.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2022.06.09-ний өдрийн А/58 тушаалаар баталсан аргачлалын дагуу АПУ ХК-аас Кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг 2025 онд хоёр удаа хийсэн ба СЗХ-ны Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс 1-р хагас жилийн хянан баталгаажуулсан үр дүнг ирүүлснийг дор үзүүлэв.

		2025.I хаяс				2025.II хаяс				
		Өөрийн үнэлгээ		СЗХ хяналт		Өөрийн үнэлгээ		СЗХ хяналт		
№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%	11	92%	12	100%	10	83%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	10	100%	10	100%	7	70%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%	6	100%	6	100%	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%	6	100%	6	100%	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%	8	100%	8	100%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%	6	100%	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%	8	100%	8	100%
8	Компанийн соёл	6	6	100%	6	100%	6	100%	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%	9	90%	10	100%	10	100%
Нэгдсэн дүн		72	71	98.6%	70	97.2%	72	100%	67	93.1%
Үнэлгээний тайлбар			1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй		1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй		1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй		1. Засаглал хэвийн буюу эрсдэлгүй	
МХБ-д бүртгэлтэй ХК-уудад эзлэх байр					2				6	

Хурлын				Баталсан тогтоолын тоо								
Д/д	Огноо	Ирц	Нийт	АПУ ХК	АПУ Дэйри ХХК	АПУ Трейдинг ХХК	М Бн Си Азия Пасифик ХХК	СББ Трейд ХХК	Спирт бал Буран ХХК	ОХУ-ын Гранд ХХК	ОХУ-ын Гранд Ист ХХК	БНХАУ өмчлөх Зүйлс Трейд ХХК
				ТҮЗ-ийн хурал	Хувьцаа эзэмшигчдийн хурал							
1	2025.02.10	100%	11	2	2	1	1	1	1	1	1	1
2	2025.03.14	100%	1	1								
3	2025.04.16	100%	1	1								
4	2025.05.20	100%	4	3			1					
5	2025.06.26	100%	4	2	1		1					
6	2025.07.31	100%	2	2								
7	2025.09.19	100%	6	2		1	1	1	1			
8	2025.10.27	100%	10	2		2	2	2	2			
9	2025.11.27	100%	3	3								
10	2025.12.03	100%	3	3								
Нийт		100%	45	21	3	4	6	4	4	1	1	1

АПУ ХК-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

"АПУ групп компани 2025 онд тавьсан зорилтуудаа биелүүлж, амжилттай ажилласан" хэмээн ТУЗ дүгнэсэн болно.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ #2

2. АПУ ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох болсон үндэслэл



СЭН И-ИН
(Seng Yi-Ying)



Шелли Коли
(Shelly Kohli)

Хуульч, эдийн засагч, улс төр судлаач мэргэжилтэй.
1998-2000: Мунбайн Кроуфорд Бэйли энд Ко, Нийтлэлийн ажилтан
2000-2002: Мунбайн Уадиа Ганди энд Ко, Хуульч
2004: Балтимор хотын орон сууцны удирдах газар, сайн дурын хуульч
2007-2008: Бангалорын Трилигал, Ахлах хуульч
2009-2010: Гургаоны Си Пи Эй Глобал, Рио Тинтогийн Энэтхэгийн салбарт Ахлах мэргэжилтэн
2010-2012: Бангалорын Женерал Электрик Интеллекент Платформс, Ахлах зөвлөх
2010-2015: Энэтхэгийн Женерал Электрик, Бангалорын Жи И Энержи менежмент, ахлах зөвлөх
2015-2019: Левин Страусс энд Ко, Өмнөд Ази, Ойрх Дорнод, Хойд Африкийн бүсийг хариуцсан Ерөнхий зөвлөхийн орлогч
2019-2022: Хиндустан Юнилевер Лтд, Хуулийн албаны дарга
2022-одоог хүртэл: Хайнекен групп, үүнд:
2022-2025: Юнайтед Брюэарис Лтд, Хууль, конллийсын захирал
2026-Одоог хүртэл: Хайнекен компани, Ази-Номхон далайн бүсийн Хууль эрхзүй хариуцсан захирал

АПУ ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүн Сэн И-Ин чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул түүний оронд хувьцаа эзэмшигч Хайнекен Азия Пасифик Пте.Лтд компаниас Шелли Колиг ТУЗ-д нэр дэвшүүлсэн.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-д заасны дагуу ТУЗ-ийг кумулятив аргаар сонгосон бол түүний бүрэлдэхүүнд өөрчлөлт орох шаардлага үүссэн үед бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэн бүрэлдэхүүнийг сонгох зохицуулалттай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ #3

3. АПУ ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн
ГИШҮҮД (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ИЙГ
СОНГОХ

Үндэслэл

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны
03 сарын 04-ний өдрийн 26/01 тоот шийдвэрээр
ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах нэр дэвшигчдийг
хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр
дэвшүүлсэн.

ТУЗ-ийн Ердийн гишүүнд нэр дэвшигчид



ПҮРЭВИЙН БАТСАЙХАН
Инженер мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч



БҮРЭНТОГТОХЫН БАТБАЯР
Эдийн засагч мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн
Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч



БАЯРЦОГТЫН ГОМБО-ЭРДЭНЭ
Хэрэглээний математикч,
эдийн засагч, санхүүч мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн Бизнес
хөгжил хариуцсан захирал



БАТСАЙХАНЫ ГАНТИГ
Бизнесийн удирдлага,
менежмент мэргэжилтэй
Шунхлай холдинг ХХК-ийн
Стратеги хариуцсан захирал



ШЕЛЛИ КОЛИ
Хуульч мэргэжилтэй
Хайнекен Азия Пасифик компанийн
Ази-Номхон далайн бүсийн
Хууль Эрх зүй хариуцсан захирал



КЕННЕТ ЧУ
Нягтлан бодогч, менежмент
мэргэжилтэй
Хайнекен Азия Пасифик компанийн
Ази-Номхон далайн бүсийг хариуцсан
Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчид



ЁНДОН-ОЙДОВЫН ГЭРЭЛЧУЛУУН
Эдийн засагч мэргэжилтэй



ОДОНЧИМЭДИЙН ОДБАЯР
Багш, Эрх зүйч мэргэжилтэй



ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ
Эдийн засагч мэргэжилтэй

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ #4

4. АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн
ЦАЛИН УРАМШУУЛЛЫГ ХЭЛЭЛЦЭЖ БАТЛАХ

ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал

Компанийн дүрмийн 7.22.8 дугаар зүйлийг үндэслэн ТУЗ-өөс 2022 оны 05 сарын 06-ны өдрийн 22/07 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийн үндсэн цалинг (татвар, хуулиар шаардсан бусад суутгалыг хасаагүй дүн) ТУЗ-ийн дарга 10 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүд 6.5 сая төгрөгөөр тогтоосныг хувьцаа эзэмшигчдийн 2023, 2024, 2025 оны ээлжит хурлуудаар өөрчлөлтгүйгээр баталсан.

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хуралд мөн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг дээр дурдсан тогтмол дүнгээр, сар бүр, мөнгөн хэлбэрээр олгон, гүйцэтгэлийн урамшуулал, аливаа нэмэгдэл хөлс олгохгүй байхаар шийдвэрлүүлэх санал оруулав.